



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/37

Бодь

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5, 9.8, Улсын Онцгой комиссын 2 дугаар тогтоолыг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/849 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/77 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт байгаа үхэр сүргийг гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хуулийн хугацаанд нь шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг аж ахуйн нэгжүүдийн малын эмч нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (А.Лхагвабаяр)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА  Р. БАТЖАРГАЛ

642201055

Сумын Засаг даргын 2022 оны 04  
дүгээр сарын 20-ны өдрийн А/37 тоот  
захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдхүүн

Ахлагч А.Лхагвабаяр (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Гишүүд Г.Эрдэнэтөр (Мал эмнэлгийн тархвар зүйч)

Ж.Лхагвасүрэн (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар (2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг (3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат (4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг (5 дугаар багийн Засаг дарга)

“Дундрашгүй баялаг” ХХК-ны малын их эмч (С.Эрдэнэ)

“Эрдэнэт таван богд” ХХК-ны малын их эмч (Л.Эрдэнэбилэг)

Малын баг эмч (Г.Эрдэнэчимэг)

оОо